

<http://mminfo.mn/news/view/3165>

## “Хил хязгааргүй Австрали” боловсролын үзэсгэлэн гарч байна

2016-09-17



“Шангила” зочид буудалд өнөөдөр “Хил хязгааргүй Австрали” боловсролын үзэсгэлэн нээлтээ хийлээ. 12:00-17:00 цагийн хооронд гарах энэхүү үзэсгэлэн нь Монгол оюутан сурагчид, тэдгээрийн эцэг эх болон боловсролын байгууллагуудад дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Австралийн боловсролын бүх шатны байгууллагуудын төлөөлөгчидтэй биечлэн уулзаж, Австралийн амьдралын хэв маяг, боловсрол, оюутны виз болон сургалтын талаарх мэдээллийг нэг дороос авах ховор боломжийг олгох аж.

“Хил хязгааргүй Австрали” боловсролын үзэсгэлэнд Австралийн 27 их дээд, мэргэжлийн сургуулиуд оролцож, тус улсын боловсролын салбарын чанар, инновацийн талаарх мэдээллийг Австралид суралцахаар сонирхож буй залуусаас гадна Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй томоохон компани, аж ахуйн нэгжүүд болон боловсролын салбарын байгууллагуудад танилцуулах юм байна. Түүнчлэн оролцогч сургуулиуд сургалтынхаа хөтөлбөр, боловсролын тогтолцоо, суралцах арга барилын тухай мэдээлэл, танилцуулга хийж, зөвлөлгөө өгөх ажээ.